

АРАБЫН ХАВАР БА ШАШНЫ ОМОГШИЛ

Д.Баярхүү *

Нэг. Шашин нөгөө өнцгөөс

Шашин бол ард түмэнд хар тамхи мэт гэсэн үгийг Хайнрих Хайнэ бодож олсон ба Маркс бусдын үгийг өөрийнхтэйгээ холбон шинээр маш хүчтэй үг гаргаж ирэх лут авъяастай байлаа. Харин Ленин шашныг маш чухалчлан тооцож үздэг, бүр үзэн яддаг. Маркс шашныг басамжилдаг, түр зуурын гаж үзэгдэл гэж үнэлж байсан бол Ленин шашныг маш хүчтэй дайснаа гэж үзэж байв. Шашинтай холбоотой болгоныг дайсагнаж үздэгээ олон удаа тэмдэглэсэн байдаг. 1913 онд Горькийд бичсэн захидалдаа Шашин шиг жигшим юм ертөнцөд өөр байхгүй гэжээ. Түүний байгуулсан төр нь бүр эхнээсээ авахуулаад нурах хүртлээ шашны эсрэг суртал нэвтрүүлгийн гайхам том аппараттай байлаа¹.

Шашин гэж юу юм бэ гэдэгт яг оновчтой хариултыг олж өгсөн хүн байхгүй. Байгааг нь дээр эшлэлээ. Дэлхийн бүх шашны туулж өнгөрүүлсэн түүх өнөө цагт жам ёсоороо давтагдаж, түүнд судлаачид тайлбар хайж байна. Туулж өнгөрүүлсэн түүхээс заримыг нь эргэж санууштай.

Нэгэн цагт эрх мэдэл нь Европ даяар үйлчилдэг цорын ганц бодгаль байсан нь христосын католик шашны тэргүүн хамба байлаа. Түүний загалмайтны шашин нь хар тамхи мэт ард түмний тархийг хордуулаад зогсоогүй, хордоогүйнх нь төлөө сая сая хүн ардыг харгислан, талцуулан бүхэл бүтэн хэдэн зуунаар өвөр хооронд нь хядалцуулж, ёстой жигшим нүгэл үйлдсэн түүх дундад зууны Европт хамаатай.

Тэнгэрийн эрхсийг судалж танин мэдсэнийхээ төлөө Н.Коперник христосын шашны залхаан цээрлүүлэх шүүхийн мөрдлөгөөс дайжин дүрвэж хавчигдсан, гариг эрхсийн хөдөлгөөний хуулийг нээсэн И.Кеплерийн нээлтийг зөвшөөрөхгүй, мөнгөөр

* Д.Баярхүү Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин, Монгол Улсаас АБНЕУ-д суугаа. Саудын Арабын Вант Улс, ЛБНИУ-д хавсран суугаа Элчин сайдаар 2008-2012 онд ажиллаж байв. Энд хэвлэгдсэн нь албан ёсны байр суурийг тусгах албагүй, ШУА-ийн тус хүрээлэнгийн судлаач-профессорын судалгааны бүтээл.

хавчин гадуурхаж, хожим шарилыг нь нурааж доромжилсон, шашны залхаан цээрлүүлэх шоронгоор дамжсан академиггүй академич Ж.Бруног лам нар амьдаар нь галд шатаасан, шашны зэрлэгүүдийн гарт эрдэмтэн М.Сервет зулын гол болсон, Г.Галилей эрүү шүүлтийг даалгүй буруугаа хүлээсэн, орчин үеийн анатомийн эцэг эмч А.Везалийг шашныхан нүглийг нь наминчлуулсан гэхчлэн урт түүх мартагдаагүй.

Англид хаант төр, парламентын хооронд олон арван жил өрнөсөн иргэний дайны галыг христосын шашин л өрдөж дэвэргэсэн. Ромын хамбыг дэмжиж католик шашныг сэргээхийг зорьсон анхдугаар хатан хаан Мария протестантуудыг хөөж туун, 300 протестантыг цаазалснаар Цуст Мария хэмээн алдаршиж байв. Католик, протестантуудын хооронд Германд зуун жил цуст дайн дэгдэж, Мартин Лютер хэмээх соён гэгээрүүлэгчийг түүх төрүүлдсэн. Шашны хүчирхийлэл, шашны мөрдлөгийн эсрэг насан туршдаа тууштай тэмцсэн Вольтер зохион байгуулалттай шашин бол үндсэндээ заль мэх хэмээн үргэлж нотолсоор дууссан юм². Үнэндээ хэн нь хэнийгээ вэ гэдэг олон зуун жилийн шашны дайныг Папын институци Европт өдөөгөөгүй гэж үү?

Нэгэн цагт монголчуудын төрөлх бөө мөргөлийг шарын шашин номхотгон дарж, сүсэгтнээ монголчуудаас олж авахаар бараг 100 гаруй жил яргалал үйлдэж, олон мянган бөө удган зайранг галд шатаан егүүтгэсэн түүх буй. Монголчуудыг талцуулж, хооронд нь байлдуулж явсан түвдийн улаан, шар шашны төлөөлөгчид түүхийнхээ эхнээс л цусан зам татуулсныг нь бид мэддэг ч тэр бүр санах дургүй. Түвдүүд 170 жилийн дотор 5 Далай ламаа өөрсдөө хороосон бол Далай лам өөрийн өрсөлдөгч гармапа буюу улаан малгайтнуудын бодийг монголчуудын гараар хөтлүүлсэн билээ. Гармапагийн лам нарын бослогыг дарахдаа Далай лам Чулуугаар өндөг хагалах мэт эр эм, хүүхэд хөгшид гэлтгүй бүгдийг нь хүйс тэмтэр, нэрийг нь ч бүү үлдээ хэмээсэн нь жүүдийг аймгалан устгах гэсэн Гитлерийн амнаас л гарах үг байлаа. Арван хар нүглээс татгалзсан шар малгайтны нийгэм байгуулах гэж үе үеийн Далай лам нар өгүүлшгүй нүгэл үйлджээ³.

Ярианы сэдэв голоосоо бага зэрэг хазайчихлаа. Эргээд үндсэн сэдэв – орчин үеийн лал руугаа орьё. XXI зууны шашин (иргэншил) хоорондын мөргөлдөөний үзэл баримтлал нь Хүйтэн дайн-ы эрин үеийн “Доминогийн онолд” шинэ хуудас нээсэн байж болно. Ерөөсөө шашин хоорондын, тэр дундаа нэг шашны урсгалууд хоорондын мөргөлдөөн бол улс хоорондын, үндэстэн хоорондын

мөргөлдөөнөөс үхэл хагацал, хохирол, эвдрэл сүйрэл, үргэлжлэх хугацаагаараа ямагт давж ирсэн түүх давтагдаж байх шиг. Үй олныг хамарсан аллага, эрүү шүүлт, хүчирхийлэл, жирийн иргэдийг суугаа нутгаас нь хэрцгийгээр хөөх цөлөх зэргээр шашны туйлшрал цааш өрнөлөө. Үүнийг Ирак, Сирийн шинэхэн түүх ягштал харуулж байна⁴.

XVII зуунд Вестфалийн гэрээгээр шашныг олон улсын бодлогоос тусгаарласан өрнийнхний тэр тохиролцоо эдүгээ XXI зуунд төгсгөл болж, эрдэмтэн Эдвард Мортимэрын хэлсэнчлэн шашин нь олон улсын асуудалд илүү ихээр голлох үүрэгтэй болох магадлалтай⁵ байна. Улс төрийн нөлөөний төлөөх тэмцэл яван явсаар соёл, шашны нөлөө тогтоохын төлөө иргэншил хоорондын мөргөлдөөнөөр солигдсон мэт. Шашны төлөөх тэр түүхэн тэмцэл эдүгээ лалын шашинд яг нүүрлэсэн юм уу гэлтэй үйл явдлууд өрнөж байна. 632–661 онд мусальманчууд 4 халифын өнгөн дээр бүх араб ертөнцийг өөрсдийн захиргаанд бүрэн оруулсан байдаг даа. Үүссэн цагаасаа л лал нь байлдан дагуулах замаар хүрээгээ тэлж байсан бөгөөд христосынхон ч мөн ялгаагүй боломжийг ер алдаагүй.

Хоёр. “Бид” ба “Тэд”, лал ба лал бус

С.Хантингтоны тэмдэглэснээр бол, лал–христосын шашны ижил төстэй байдлаас мөргөлдөөн үүсдэг. Улс төрийн итгэл үнэмшлээсээ илүүтэй энэ хоёр шашин хоёул нэг бурханд сүсэглэдэг бөгөөд өөр шашны шинэ бурхныг хүлээн зөвшөөрч чаддаггүй, хоёулаа ертөнцийг “бид” ба “тэд” гэж хоёрдмол байдлаар хүлээн авдаг. Хоёулаа универсал төгс, тийм учраас цорын ганц үнэн мөнийн шашин хэмээн өөрсдийгөө тунхагладаг. Шашинд итгэдэггүй бусад хүмүүс цорын ганц үнэн мөнийн тэр шашинд нь итгэх хэрэгтэй хэмээн хоёул баг итгэсэн, хоёулаа итгэгчдийг элсүүлэх даалгавартай. Жихад ба Загалмайтны аян дайн хэмээх зэрэгцсэн үзэл баримтлал нь өөр хоорондоо адил талыг илэрхийлэхээс гадна энэ хоёр шашныг дэлхийн бусад үндсэн шашнуудаас ялгаж өгдөг аж⁶.

Энэ хоёр универсал төгс шашны хооронд даруй 1000 жил⁷ ил далд мөргөлдөөн үргэлжилж байна. Эдүгээ мусульманчуудын шашны омогшлыг хэн, юу өөгшүүлж байна вэ? Юуны өмнө Хүйтэн дайнд ялсан өрнийнхний ялалт тэднийг цэнэглэлээ. XXI зууны даяаршил, мэдээллийн их хувьсгал, технологийн дэвшил тэднийг сөргөөр хурцаллаа. Тэдний өөрсдийнх нь нийгэм, шашны итгэл үнэмшилд нь XXI зууны даяаршил, мэдээллийн их хувьсгал, технологийн дэвшил, ардчилал заналхийлж байдагт тэд зэвүүцлээ. Өрнийн соёлыг тэд

материаллаг, завхарсан, уналтад орсон, ёс суртахуунгүй хэмээн үздэг. Тэд өрнийн соёлыг нүглээр дүүрсэн, толгой эргүүлэм гэж үзээд “амьдралын хэв маягтаа нөлөөлүүлэхгүйн тулд эсэргүүцэх хэрэгтэй гэж байнга анхааруулдаг. Өрнийнхөн төгс бус, алдаатай, хуурамч “номын шашин” шүтдэгийнх нь төлөө бус, ерөөсөө ямар ч шашин шүтдэггүйнх нь (шашнаас ангид секуляризм) төлөө лалынхан тэднийг илүү их буруутгаж байна. Мусульманчуудын нүдээр бол, өрнийнхний секуляризм, шашингүйн үзэл (атеизм) бол ерөөсөө ёс суртахуунгүй явдал, өөрсдийг нь бүтээсэн христосын шашнаас нь илүү хорлол юм гэнэ. Хүйтэн дайны үед дайснуудынхаа духан дээр өрнийнхөн “бурхангүй коммунизм” гэдэг пайз наадаг байсан бол эдүгээ иргэншил хоорондын мөргөлдөөний эринд мусульманчууд өрсөлдөгчөө “бурхангүй өрнийнхөн” гэж хаяглах болсныг эрдэмтэн С.Хантингтон⁸ олж харсан байдаг.

Ингээд өрнийнхний ардчилал, даяаршил, мэдээллийн их хувьсгалыг сөргүүлж шариат цэцэглэсэн цэвэр лалын нармай гүрэн байгуулах уриа тунхаг бүхий салафит, ваххабитууд Арабын хувьсгалаар өндийж, амилж, сэргэн боссон нь энэ юм. Салафитуудаар өнгөлсөн Цоо шинэ Аль-Каеда (Социнтерн гэдэг шиг Лалын интернационал гэж нэрлэж эхлээд буй) бий болсон нь Арабын хавар-ын нэг гол үр дүн ажээ. Салафитуудаар өнгөлсөн гэсэн дээрхи санаа бол салафит бүлэглэлүүдийн сүлжээ, тэдний зэвсэглэсэн асар их нөөц хүчнийг хэлж буй.

Салафит лалууд эдүгээ Сирид идэвхжихийн хэрээр тэднээс түгших болгоомжлох явдал хөрш орнуудад нь түгээмэл байна. Сирид лалын фундаменталистууд засгийн эрх авбал Ирак болон нийт Ойрхи Дорнодын бүс нутагт шууд аюул занал учирна гэж Иракийн лалын шиитийн удирдагчдын нэг Баян Жабер аз-Зубайди анхааруулав. Ваххабит-салафитын хөдөлгөөн Сирид засгийн эрхэнд гарч ирнэ гэдгээс иракчууд бид үнэхээр айж байна хэмээн иракийн ТВ-ээр яриад, Башар Асадыг зайлуулсан тохиолдолд Афганистан дахь талибын дэглэм шиг л юм болох байх. Засгийн эрх авсан салафит лалууд Аль-Каеда-тай холбоо тогтоон дараагийн ээлжинд Ирак-Сирийн хооронд дайн дэгдээх болно хэмээн сэрэмжлүүлжээ.

Ваххабит-салафитуудын дараагийн томхон зорилт нь шиитийн хагас хавирган сарыг утсгах явдал болно гэсэн санааг Al Jazeera ТВ-ээр ярьж байв. Ингэснээр Сирээс гадна Иран, Ирак, Ливан дахь шиитүүдийн эсрэг эцэс төгсгөлгүй дайн эхэлнэ. Уламжлалт аядуу ислам-ваххабизм хоёр, лалын суннит-шиит хоёр урсгалын хэн нь хэнийгээ вэ гэсэн ширүүн тэмцлийн үедээ лалын шашин

шилжин орлоо хэмээн үзэхээр үйл явдал зөвхөн Арабаар төдийгүй олон улсжин лалын орнуудад, тэр ч бүү хэл Монголын архан талд Оросын мусульманчуудын хүрээнд өрнөж байгааг сайтуудын мэдээнээс өлхөн олж үзнэ.

Гурав. “Лалын хувьсгал” ба християнчуудын өлгий нутаг

Катар дахь Open Doors хэмээх христосын шашны олон улсын буяны байгууллагын мэдээгээр бол энэ шашинд элсээ л бол хүн бишэд тооцогдож хүчирхийлэлд өртдөг үзэгдэл Персийн булангийн зарим улсад түгээмэл аж. Мөнгөний төлөө хар ажил хийхээр тийшээ зүглэсэн гадаадын християн ажилчид туйлын дорд нөхцөлд аж төрж, цуглаж мөргөл хийх нь хориотой, хулгайгаар мөргөлөө үйлдэж, Саудын Арабт бол исламаас өөр аль ч шашин хориотой, мусульман хүн христосын шашинд элсвэл цаазын ялтай байдаг аж. 2012 оны хавар, Саудын Арабын Дээд муфтий шейх Абдул Азиз аль-Ашейх гэгч нөхөр христосын сүмүүдийг нурааж устгах хэрэгтэй хэмээн мэдэгдэж, Арабын хойгоос загалмайн шашинтнуудыг хөөж гаргахыг уриалсныг Египет, Сирийн лалын мухар сүсэгтнүүд баяр хөөр болон хүлээн аваад лалын шашныг завхруулах замдаа эргэлтгүй орсон билээ. Лалын өвийг сэргээх нийгэмлэгийн сан гэгч Кувейтын ТББ-ын төлөөлөгчидтэй уулзахдаа:

- Арабын хойгт хоёр шашин байж огт таарахгүй хэмээн зөнч Мухаммед гэрээсэлсэн тул мечетээс өөр ямарваа сүм хийд байх тухай яриа огт байшгүй хэмээн муфтий аль-Ашейх ийнхүү уриалжээ.

Кувейтын парламентад олонхи болсон исламистууд ч тус орноос християнчуудыг гаргах, тэдний сүм хийдүүдийг арчиж үгүй болгох мэдэгдэл тэр үед хийж, улмаар 2012 оны 2 дугаар сард парламентаасаа тусгай тогтоол гаргуулжээ. Тэр нь одоо тус оронд алдаг оног ажилладаг ганц нэг сүмийг (байхгүйтэй адил) устгах тухайд бус, ирээдүйд огт бариулахгүй гэсэн санаагаар хэлэгдсэн үг ба ерөөсөө Арабын хойгт биетэй бодитой, ажиллаж буй христосын сүмүүд байхгүй атал аль-Ашейх, кувейтын хууль тогтоогчид ийнхүү заналхийлсэн мэдэгдэл хийж хийрхэх болсон нь християнчуудаар “хахаж байгаа” Египет, Сири рүү хандсан уриа дуудлага болж хувирав.

Яг ийм өнцгөөс Саудын Араб, Катар нь египетийн Лалын ахан дүүс-ийг, сирийн босогчдыг дэмжих бодлогоо хэрэгжүүлж байна. Гэтэл Египет нь коптын, Сири нь өөрөө християнчуудын онгон дагшин газар нутаг байдаг. Христосын шашин, шавь нараар өтгөн орон гэвэл чухам эртний Египет, эртний Сири, эртний

Израиль байсан гэдэг дээр түүхчид санал нэгддэг. МЭӨ IV мянганд Сирид иргэншил үүсч, Дамаск нь энэ дэлхийн нэн эртний цөөхөн нийслэлийн нэг болсон ба христосын шашны түүхэнд Сири өөрөө чухал байр эзэлж ирсэн. Дамаск орох замд гэгээн Павел номоо айлдаж мөргөлчдөө цуглуулж явсан, Сирийн Антиоход Христосын шавь нар өөрсдийгөө анхны христианчууд хэмээн нэрлэж байсан түүх буй.

Албан ёсны статистикаар эдүгээ Сирийн 23 сая хүн амын 86 хувь нь мусульман, түүний 10-12 хувь нь алавит ба шиит, хүн амын 10 хувь нь христиан, тэр 10 хувийн тал нь үнэн алдартны шашинтнууд, үлдэх нь католик, армян апостол христианчууд. Асадынхнаас өмнө ч, Асадын үед ч сирийн христианчууд өөрийн шүүхтэй, иргэний асуудлаа тэндээ шийддэг, хуримлах, гэр бүл цуцлахаа тэндээ шийддэг, лалын шашны баяруудаас гадна тэд пасха болон Зул сарын баяраа тэмдэглэдэг, Дамаскт хэд хэдэн дүүрэгт христианчууд тайван аж төрж ирсэн. Зарим судалгаагаар үнэн алдартны шашны өлгий нутаг нь Сири гэж шууд ойлгогдоно. Энэ шашны загалмайлсан эцэг Петр, Павел, Иоанн Златоуст, Иоанн Дамаскин нар Сирид ном тавьж, шавь нараа сургаж мөргөлчдөө дагуулж байсан ба 1342 онд Антиохийн үнэн алдартны⁹ сүмийн төв нь Дамаск руу шилжин байрласан байдаг. Цаашлаад үнэн алдартны өөр нэг урсгал болох сири-яковит үнэн алдартан 680 000 хүн Сирид бий. Энэ урсгал бол эртний дундад дорнодын үнэн алдартны 6 том урсгалын нэг нь. Нэр хүнд нөлөөгөөрөө копт, армян апостол шашинтай зэрэгцэнэ. Сири бол Исүс Христосын төрөлх хэл-эртний арамей хэлийг авч үлдсэн дэлхийн цорын ганц улс гэх мэт түүхэн олон баримт дурдаж болно.

Лалын ахан дүүс-ийн өнгөн дээр салафит лалуудын дайралт доромжлолыг хангалттай амсан буй Египетийн христиан-коптчууд ч түүхийн баялаг өвтэй. Тэд бол арабчууд нүүдэллэн ирж хүчээр арабжуулалт, лалжуулалт хийхээс аль өмнөх үеийн түүхэн христианчуудын удам судар. Хэдийгээр 15 сая копт байна гэх боловч Арабын хавар-ын шуурганаар тасралтгүй цөөрч буй. Ойрхи Дорнод дахь христианчуудын томхон нийгэм Египетэд байж ирсэн ба ихэнхи копт нь Коптын үнэн алдартны сүмд мөргөдөг сүсэглэдэг. Коптын үнэн алдартны шашин V зууны дунд үеэс Египетийн гол шашин болсон, эртний египетийн копт хэл хадгалагдан үлдсэн, тийм хэлээр ярьдаг мэддэг 300 гаруйхан хүн байна. Сүм нь энэ хэлээр номоо тавьдаг. Энэ чинь түүх-соёлын өв биш гэж үү?

Антиохийн үнэн алдартны сүмийн мэдээнээс эшлэе. Алеппо

(Халеб) муж бол Сирийн хүн амын 25 хувь аж төрдөг, мужийн төв Алеппод хүн ам хамгийн их шигүү суурьшсан, тэнд Алеппогийн митропол-Антиохийн шашны том төв буй, 2013 оны 2 дугаар сард авсан мэдээгээр энэ хотын үлэмж хэсэг босогчдын гарт орж, хотын 20 хувь балгас болж, дэд бүтцийн 80 хувьд сүйрчээ. Христосын сүмүүд ч олноороо үгүй болж, христианчууд нь дүрвэн зайлсан буюу амь үрэгдсэн байлаа.

Оросын Үнэн алдартны шашны их хамба патриарх Кириллийн зовинолын үгсийг энд бүрэн эхээр нь буулгая. Тэрээр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинд хандаж ингэж бичжээ.

- Өнөөдөр Сирид өрнөж буй мөргөлдөөн, гамшгийн уршгаар энэ улсад христосын шашин бүрэн устгагдаж арчигдах аймшигт төлөв харагдаж байна. Хэрэв ингэвээс ойр хавийн улсууд нь юу ч хийж чадахгүй.

- Ойрхи Дорнодод христосын шашин арчигдан алга болохыг тэвчишгүй, тийм үйл явдалд бүү хүрээсэй.

- Өнөөдөр Сири дэх цэргийн ажиллагаа, мөргөлдөөний хөлд христианчууд үхэж үрэгдэж байгаа нь Ойрхи Дорнодоос тэд мөд арчигдаж үгүй болно гэсэн үг.

- Жирийн хүмүүсийн хувьд ч, үнэн алдартны шашны хувьд ч, дэлхийн соёлын хувьд ч энэ нь жинхэнэ эмгэнэл, эцэстээ иргэншлийн сүйрэл болно.

- Бидний итгэл үнэмшил бүгд тэндээс эхтэй. Тэндээс манай шашин, бидний итгэл үнэмшил угшилтай, тэнд байсан эртний патриархатын төлөөлөгчид нь өнөөдөр энд байна¹⁰ гэжээ (Энд гэдгээр ОХУ, Москваг хэлсэн хэрэг)

Дэлхийн түүх-соёлын энэ бүх өв өнөөдөр Сирид дэгдсэн ардчилсан бослого-ын хөлд нэрвэгдэх аюултай ийнхүү тулгарчээ. Сири дэх олон үндэстний радикал-исламистууд хосгүй энэ их өв, түүнийг тээгч христианчуудын эсрэгжихад морджээ. Христосын өрнийнхүний иргэншил цэцэглэсэн тэр нутгаас европын иргэн-сайн дурын мусульман дайчид Сири рүү цувсаар. Тэд энэ дайнд хатуужаад Европтоо хэн болж очих, хэрхэн омогшихыг хэлж таашгүй. Гэтэл Европын орнууд сирийн сөрөг хүчинд зэвсэг нийлүүлэх дээр тавьсан хоригоо цуцалж байдаг. Лондонгийн гудамжинд гэгээн цагаан өдөр англи цэргийг толгойг хяргачихсан исламистуудаа зүгээр л сул зэвсэглэхчээ байгаатай адил бус уу хэмээн ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин "G-8"-ын бүлгийн дээд хэмжээний уулзалтад оролцохдоо асуулт тавьж байсныг санаж байна.

Дөрөв. Христианчууд “Лалын хувьсгал”-ын хөлд

2012 оны хавар Иерусалим, Александриа, Антиохи, Киприйн үнэн алдартны шашны хамба нар Кипрт уулзахдаа Арабын хаварын хөлд загалмайн шашинтнууд зовж тарчилж дууслаа гэх харанга анхлан дэлдсэн. Тэд Сирийн байдлыг сэтгэл түгшин хэлэлцэж, улмаар Ойрхи Дорнодын христиан хүн амыг хамгаалах асуудлыг дэлхий дахины анхаарлын төвд аваачихыг зорьсон. Хамгийн ихээр зовлон туулж сорилт давсан христианчууд Сири, Ливанд байгаа талаар Антиохийн үнэн алдартны патриарх Игнатий ярьсны дараа түүнийг дэмжин нийт Африкийн патриарх Феодор, Грекийн Гадаад хэргийн дэд сайд Доллис мэдэгдэл хийж байв. Ойрхи Дорнодын христосын сүмүүдийн нэгдсэн төлөөлөгчдийг Европын Холбоо, НҮБ руу илгээж, эгэл бус байгаа энэ бүс нутгийн христианчуудыг хамгаалах асуудлыг олон улсын түвшинд гаргаж тавихыг Киприйн архиепископ Хризостом уриалсан нь дэмжигджээ¹¹. Асуудал иймдээ тулсан байна гэдгийн ганцхан баримт нь энэ.

Сири бол арабын национализмын уламжлал бүхий Ойрхи Дорнодын хамгийн шашинжаагүй улс, зүйрлэвээс Турктэй төстэй. Зэвсэгт бослогын өнгөн дээр жирийн сиричүүдийн нүдэн дээр шашинжаагүй тэр байдал нь тэс өмнөө болжээ. Бослогод эхнээс нь оролцсон исламистууд тус улсын нүүр царайг эрс өөрчилжээ. 2013 оны хавар байлдаан Дамаск болон бусад томхон хотуудад шилжин, хот дотор гудамж, байшин, хорооллын төлөө тулалдаж байх үед энэ нь нэн тодорхой харагджээ. Нийслэлийн христиан дүүргүүдэд (Баб Тума, “Баб Шарки, Кассаа, Гассани) ид тулалдаж байх үед суннит бус шашинтны хувь заяа хэрхэх нь нэн тодорхой болсон юм.

Хэрэв зэвсэгт босогчид, тэдний эгнээнд буй террористууд засгийн эрх аваа л бол сирийн христианчуудыг хядлага хүлээж буй хэмээн Ойрхи Дорнод судалдаг экспертүүд үзсэн ба түүнийг нотлох баримт интернэтийн мэдээнээс салахгүй байна.

- Хэрэв исламистууд Сирид ялалт байгуулбал Сири дэх шашны цөөнхи болох христианчууд, алавитуудад нь маш гунигтай, бүр эмгэнэлтэй хувь заяа тулгарах болно. Өчүүхэн цөөн тоотой сирийн жүүдүүдийн тухайд бол яриад ч хэрэггүй. Сирийн курдууд ч бусдаасаа дугах юмгүй зовлон амсах болно¹² хэмээн оросын дорно дахинч эрдэмтэн Евгений Сатановский тэмдэглэжээ.

Сирийн 2 сая христианчууд өнөөг хүртэл Асадын дэглэмийн хамгаалалтад байж ирсэн бол энэ дэглэм нурвал тэд маш хүнд байдалд орно хэмээн судлаач И.Шамир, судлаач Р.Силантьев нар дүгнэжээ¹³. Хүнд байдал гэдэг нь цэвэр лалын төлөө тэмцэж буй

радикал исламистууд христианчуудыг шууд хяхаж хавчих, хөөж туух, дүрвүүлэх, лам хуваргуудыг нь хөнөөх, сүмүүдийг нь нураах, эсвэл христианчууд нь амь гуйж асар их мөнгөн төлбөр исламистуудад төлөх гэх зэргээр авирлахыг хэлж буй хэрэг.

Обсерватор христианофоби гэх Францын ТББ-ын ноцтой мэдээлэл байна. Хэрэв энэ мэдээ нотлогдвол олон улсын эрүүгийн шүүх анхаарлаа хандуулж таарна. Фронт Аль-Нусра-гийн радикал дайчид христосын шашны хоёр том митрополит ламыг хулгайлж сураггүй болгосон нь “хувьсгалын үйл хэрэгт ноцтой хохирол боллоо”¹⁴ хэмээн Сирийн сөрөг хүчнийхэн өөрсдөө мэдэгджээ. Аль-Каеда-гаас дутахгүй аюул тарьж буй Фронт Аль-Нусра-гийн талаар сирийн босогчид өөрсдөө гайхшаа (юун зэвсэгт нэгт ахан дүүс!) баржээ.

Лалын халифатын дайчдын бригад, түүний нэг толгойлогч Абу Али Аль-Мухайер гэгч хар багтай нөхрийн видео уриалга байна. Асадын дэглэмийг сулрх натаал нь бөөнөөр нь алаад бай, ялангуяа буруу номтон, харь шашинтнуудыг бүү хайрла, бүү өршөө, харь шашинт охид хүүхнүүд, гэлэнмаа нарыг нь хүчиндээд бай гэх түүний үгс юу илтгэнэ вэ? Иорданаас очсон салафитын шейх Ясир аль-Ажлавни гэгчийн YouTube-д тавигдсан уриалга байна.

- Цэвэр лалын Сирийг нэгч христиангүйгээр цогцлуулна. Нийт мусульманчууд Асадын эсрэг дайнд оролцож, шариатын Засгийн газар байгуулах хэрэгтэй. Чингэхдээ суннит биш л бол, христиан, алавит, шиит бүсгүйчүүдийн зоригийг нь мохтол хүчиндээд бай!

- Жихалын дайчид минь, би Та нарт зөвшөөрөл олгоё. Лалын суннит урсгалынх л биш бол тааралдсан мальк аль-ямин¹⁵ эмэгтэйчүүдийг хүчиндээд бай!¹⁶

Саудын Арабын шашин номлогч Мухаммад аль-Ариффи гэгч бас ийм уриалга гаргаж, харь шашинтныг хашраах нэг арга нь хүчин гэж үзсэн байх аж.

- Өөр шашинтай л бол хулгайлаад хүчиндээд байх зөвшөөрлийг Шариатын зөвлөлийн гишүүн шейх Абу Хумам Аль-Атари олгосон тул бид дайчиддаа зөвшөөрөв хэмээн Минбар Аль-Туахид Валь-Жихад гэх лалын радикал бүлэглэл сайтдаа бичжээ.

- Аль-Атарийн үгс: Християн, жүүд хүний ангилалд багтдаг байна уу, үгүй юу падгүй. Исламтай дайсагнаж л байгаа бол тийм үл итгэгч эмэгтэйчүүдийг хүчиндэх нь шариатын хуулиар бол гэмт хэрэг биш¹⁷.

Мусульман лидер Хашим Камен гэгч канадын Toronto Sun сонинд ярилцлага өгөхдөө, христиан бүсгүйчүүл хүчиндүүлэх нь

өөрсдийнх нь хохь, яах гэж даруухан хувцаслаагүй юм¹⁸ гэж загнасан байх аж. Олон улсын аврах хороо гэх ТББ-ын тэмдэглэснээр, Сириэс дүрвэн зайлах нэг шалтгаан нь эх захгүй энэ хүчин гэнэ. Исламстууд хүчин хийхдээ бөөнөөрөө үйлдэх нь элбэг, олзлогдсон эмэгтэй үхэхээс өөр замгүй. Гэр бүл, үр хүүхдийнх нь нүдэн дээр тэр булай хэргээ үйлдчихээд тамлаж ална. Гадаадаас ирсэн хөлснийжихадистуудад сирийн хэн байх нь ер падгүй.

Ийм эмгэнэлт хувь тавилан католик, халкидон, үнэн алдартны бүх сүсэгтнүүдэд нүүрлээд байна. Хомс хотод 2012 онд болсон үйл явдлыг үүний жишээ болгон нэрлэж болно. Үй олноороо депортац хийж, хөрш Иордан руу дүрвэсэн, дүрвэж амжаагүй үлдсэн олон зуун християнчуудыг босогчид олзлон авч, буудаж алсан ба дүрвэж амжсан 138 000 християнчуудын гэр орныг цөлмөөд дараа нь галдан шатаасан болохыг католикийн Фидес мэдээллийн агентлаг мэдээлсэн. Грекийн үнэн алдартны сүмийн мэдээлснээр сирийн босогчдын талд байлдаж буй чеченүүдийн гарт христосын хэд хэдэн гадаад, сири епископ барьцаалагдсан ба Фронт аль-Нусра гэгч радикал лалын отряд үүний хариуцлагыг хүлээж буй ажээ. Бүх митрополит, архиепископ, епископууд барьцаалагдан, алагдахгүй гэх ямар ч баталгаа алга.

Цэвэр лалын улс байгуулахад 2 сая християн саад болох учраас Сирийн нутаг дэвсгэрээс алга болгох ёстой аж. Цаана нь нэг сая алавит үлдэж байна. Тэднийг ч мөн шашны ялгарлаар нь хядаж дуусгах төлөвлөгөөтэй.

- Хэрэв ваххабитууд дангаараа засгийн эрх авбал энэ оронд ганц ч християн, мөн ганц ч шиит, ганц ч алавит үлдэхгүй, ваххабитууд бол християнчуудыг нэг нүдээрээ ч үзэж чалдахгүй, анхны боломж л олдох аваас шууд устгана. Ирак, Сомали, Ливид християнчуудыг үлдэн хөөсөн шиг үзэгдэл давтагдана хэмээн эрдэмтэн Силантьев сэрэмжлүүлж¹⁹ байна.

Ваххабизмын эх орон гээд буй Саудын Арабт уг нь эрт дээр үеэс християнчууд, мөн жүүд нар аж төрж байсан, тэднийг үзэн ядсан ваххабитуудын олон зуун жилийн нөр их чармайлтын үр дүнд энэ оронд одоо ганц ч харь шашинтан байхгүй болсон. Ийм сценар Асадын дараахи Сирид нүүрлэнэ хэмээн дээрхи хоёр эрдэмтэн үзжээ.

Сириэс дүрвэж гарсан үнэн алдартны шашны нэгэн патриархын ярьснаас бол мусульманчуудын зүгээс доромжлол эгүүтгэлийг тэд хангалттай амсаж байгаа юм байна. Тэрс шашинтны эсрэгжихадад нь дэлхийн 29 улсаас сайн дураараа очсон мусульманчууд байлдаж,

Саудын Араб, Катараас цалинжиж, сирийн мусульман босогчидтой хамтран хүчирхийлэл үйлдэж байгаа аж. Тэдний гарын шүүсийг үнэн алдартны шашны лам нар их амсчээ. Нүдийг нь ухах, ясыг нь хуга цохих, эд эрхтэнийг ухаж гаргах, шөрмөслөх зэргээр эцэг Фадлей аль-Халдадыг алсан (гадаадын зарим хэвлэлд исламофашизм гэж тодорхойлсон нь бий) ба маш олон лам хуврага, епископ, гэлэнмаа нарыг авч яваад сураггүй болгосон гэж байна.

Дамаск зэрэг томхон хотуудын христиан хороолол руу амиа золиослогч террористыг илгээдэг болж байна. Дамаскийн грек үнэн алдартны сүмийн ойролцоо 2013 оны 6 дугаар сард анхны дэлбэлэлт хийснийг шашин хоорондын мөргөлдөөнийг дэвэргэх зорилготой гэж үзэн ОХУ-ын ГХЯ мэдэгдэл хүртэл гаргажээ. Нийслэл хотын түүхэн хэсэг – Үнэн алдартны Антиохийн патриархын өргөөний ойролцоо, Марьямия сүмийн дэргэд амиа золиослогчдыг ийнхүү исламист босогчид илгээснээр “Цэвэр лалын улс” буй болгох цаад зорилго, хэрэгжүүлэх тактик нь ч ил боллоо.

Гадаадад садантай, мөнгөтэй христианчууд нь дүрвэж алга болсон, тиймгүйнүүд нь шинэ төрсөн эмируудэд жизья (амьд үлдэхийн тулд христианчуудын төлдөг онцгой татвар) төлж, эмэгтэйчүүд нь нүрээ гивлүүрээр бүтээн дагжиж суугаа ба жизья төлөхгүй бол үхэл рүүгээ гэсэн зарчим үйлчилж эхэлсэн аж. Исламист жихадистуудын (бас сионистуудын!) харгислалаас хамгаалах нэгэн хамгаалагч Сирид гарч ирсэн нь ливаны шиитүүдийн Хээболла хөдөлгөөний толгойлогч шейх Насралла болжээ. Израилийг зүйл дуусгая гэх Насраллагийн мөнхийн афоризм нь Палестин, Ливан дахь эсэргүүцлийн хөдөлгөөнд нь тусалсаар ирсэн Иран, Сирид талархал илэрхийлэх, мусульман-шиитүүд хэзээ ч Палестинаас нүүр бууруулаагүй гэх талархал, амлалтаар баяжаад хөвөрч өглөө. Түүний хэлснээр бол Ливаны хил рүү мянга мянган экстремист тулж очсон ба Ливаныг хамгаалахын тулд зэвсэгт отрядуудаа тийш нь илгээн байлдуулахаас аргагүй байгаа гэнэ.

- Сири дэх экстремистүүдийн эсрэг тулалдаанд Башар Асадын дэглэмийг заавал ялуулна, ялуулахаас ч өөр арга алга, хэрэв сирийн мөргөлдөөнд үл эвлэрэх исламист-суннитүүд ялах аваас Сири төдийгүй Ливаны нийт хүн амд-суннит, шиит, друз, христиан гэж ялгалгүй бүгдэд нь аюул учирна хэмээн мэдэгдэв.

Христианчуудыг егүүтгэх эл парадокс ганц Сириэр түгсэн юм биш. Ливид ч суларсан улс төрийн вакуумыг исламистууд бөглөхөөр уухайлаад эхэлсэн тухай баримт ирсээр байна. Энэ явдал Калдафын дэглэмийг түлхэн унагасны дараа Триполийн цэргийн губернатороор

Афганистанд Осам бин Ладены командлал дор зөвлөлтүүдтэй байлдаж явсан Абдель-Хаким Бельхаж гэгч террористыг томилсноос эхтэй. Тус улсад 100 000 христиан Кадлафийн дэглэмийн дор амар тайван аж төрж байсан бол зэвсэгт бослогоос хойш ердөө хэдхэн мянга үлдэж, тэд нь дарлал доромжлол, хавчилга, хүчирхийллийн золиос болж буй аж²⁰. “Прозелитизм” гэх ял²¹ тохож христианчууд руу довтлох, баривчлах, эрүү шүүлт тулгах, сүмийг нь сүйтгэх явдал байнга үзэгдэх болжээ. 2013 оны 3 дугаар сард прозелитизмын хэргээр олон арван копт-христианчууд “алганы амт” үзсэн гэж байна. Гэлэнмаа нар доромжлолыг тэсэлгүй Ливийг олноороо орхин оджээ. Бенгазид 48 копт баривчлагдан эрүү шүүлт амссанаас нэг нь үхсэн ба энэ явдлын дараа Европын Холбоо эсэргүүцлийн мэдэгдэл гаргажээ.

Тав. Дүгнэлт

Арабын хавар-ын хөлд мусульман-суннитаас бусад шашинтнууд нь ийнхүү хуйхлагдлаа. Би хэргээр энэ өгүүлэлдээ дүгнэлт болгон оруулах саналтай нэгэн үйл явдал ба түүнд өгөх жич дүгнэлт байна. “2011.04.01”-энэ өдөр дэлхий нийтийг донсолгосон мэдээ Афганистаны Мазари-Шариф хотоос тархсан билээ. Баасан гаригийн их мөргөл өнгөрөөгөөд олон мянган лалын мухар сүсэгтнүүд “АНУ-д үхэл! Израильд үхэл!” хэмээн орилолдон уйлалдсаар НҮБ-ын Төлөөлөгчийн газар руу уулгалан дайрч дор хаяж 20 хүн, түүний дотор НҮБ-ын ажилтан, өөрсдөд нь буян үйлдээд сууж байгаа гэм зэмгүй 7 ажилтныг алж, хоёрынх нь толгойг тасдаж, байшинг нь эвдэж шатаасан, үгээр эвлүүлэн бичихийн аргагүй балмад хэрэг өдөөжээ. Хаа хамаагүй АНУ-д христосын нэг сүмийн пастор Коран судар шатаалаа хэмээж уурссан мусульманчууд хилэгнэж байгаа нь тэр гэнэ. Мусульман-христианчуудын хоорондын аймшигт дайны гэрч нь манай гариг өөрөө болох тухай уриалга хэрэгжиж байгаа нь энэ юм болов уу? Ийнхүү Афганистанд НҮБ-ын ажилтнуудыг гэсгээн цээрлүүлсэн энэ “2011.04.01” бол НҮБ-ын түүхнээ арилшгүй хар өдөр болж үлдлээ. Цаашид олон улс орон, ард түмэн, сүсэгтнүүдэд гашуун сургамж болж үлдээсэй! Ямар сургамж вэ?

- Эрх зүйт төр, хууль тогтоомж, нийгмийн харилцааны эрхэм нандин бүхэн лалынхаар солигдох;

- Лалын шашны хэл, бэлгэдэлийг илүүтэй хэрэглэх;

- Лалын шашны зан үйлийг хэт дээдлэх;

- Лалын боловсролыг түгээн дэлгэрүүлэх;

- Лалын шашны сургуулийг олноор байгуулах, төрийн мэдлийн

сургуулиудыг лалжуулах;

- Эмэгтэйчүүд гивлүүр алчуур зүүх, эрчүүд сахлаа хусахгүй байхаас эхлээд лалын дэг жаягийг нийгэмд нэвтрүүлэх;

- Сөрөг хүчнийг лалынхнаар дүүргэж секуляр Засгийн газрын эсрэг босч тэмцэх;

- Лалын шашинт улс орнуудын олон улсын эв нэгдлийг уриалан дуудах нь эцсийн бүлэгтээ ийм л эмгэнэлд хүргэнэ²².

Америк эрдэмтэн Жон Эспосито ийнхүү тэмдэглэсэн нь өнөөгийн лалын Афганистан дээр харагдаж байгаа нь энэ. Лал сэргэн мандсаны үр дүн, бүтээл нь ердөө л энэ, Мазари-Шарифт болсон үйл явдал. Энэ баримтыг татаж авчран Арабын орнууд дээр жишээлээд үзэхэд Сири, Ливи, Египет, Тунис, ер нь хаа ч адилхан даа!

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ:

¹ Баабар, Баярхүү. Ертөнцийн шинэхэн түүхийг бүтээгчид, Непко хэвлэлийн газар, 2012, 6, 22-23 дахь тал

² Майкл Х.Харт. Дэлхийн түүхийн суут 100 хүн, УБ, 2012 – номд бичигдсэн Лютер, Кальвин, Галилей, Кромвель, Декарт, хатан хаан Изабелла, хатан хаан Елизавета зэрэг олон хүний намтраас тодорхой танилцана уу.

³ Erik D. Curren. Buddha's Not Smiling: Uncovering Corruption at the Heart of Tibetan Buddhism Today, 2008,

Нийтлэлч Д.Батбаярын “Монголын энх амгалан”, “Тэнгэрийн улаач нар”, Далай лам, Монгол, хойд дүр” зэрэг олон нийтлэлд (bat-bayar.niitlech.mn) энэ тухай бий.

⁴ BREAKING UP: Iraq's Crisis State: Sectarian Polarization Reaching All-Time High, live.huffingtonpost.com, 15 August 2013

⁵ Edward Mortimer. Christianity and Islam, International Affairs, 67 (Jan. 1991)

⁶ Самуэль Хантингтон. Иргэншил хоорондын мөргөлдөөн: Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам (Samuel P.Huntington. The Clash of Civilizations and the Remaking of World Order, Touchstone Books, London, 1997), ННХ, Монсудар, 2005

⁷ 1095. 11.27-нд Ромын пап II Урбан ариун газар нутгийг лалын тэрс шашинтнуудаас чөлөөлөхийг уриалан дуудаж Загалмайтны аян дайн эхлүүлснээс эхлэн тооцож болно. Пап Урбаны уриалснаар бол, ариун газрыг чөлөөлөх загалмайтны аян дайнд явж оролцох нь шашны бүх цээрлэлийг орлох төдийгүй аян дайнд оролцогч христиан болгон бүх нүглээсээ ангижрах буянт үйлс нь байв. Энэ

аян дайн бараг 200 жил үргэлжилжээ.

⁸ Самуэль Хантингтон. Иргэншил хоорондын мөргөлдөөн: Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам (Samuel P.Huntington. The Clash of Civilizations and the Remaking of World Order, Touchstone Books, London, 1997),

⁹ Антиохийн үнэн алдартан гэж эдүгээ дэлхийд 2 сая шашинтан байдаг бол тэдний сая гаруй нь (сирийн хүн амын 5 хувь) Сирид, 400 мянга нь Ливанд (тэндээ хүн амын 10 хувь), цаашлаад АНУ, Европт цөөхөн тоогоор аж төрж байгаа ба номлолоо грекээр тавьдаг. Сирид араб, грек хэлээр зэрэг уншдаг. ННХ, Монсудар, 2005

¹⁰ Патриархи выразили обеспокоенность судьбой христиан в Сирии, РИА Новости – сайт, 25.07.2013

¹¹ 27 марта на Кипре состоялась встреча предстоятелей Ближневосточных Православных Церквей, agionoros.ru, 28 марта 2012 г

¹² Конфликт между этносами в случае раскола Сирии может привести к геноциду и миллионам погибших, itar-tass.com, 02/07/2012

¹³ Сирия: что ждет христиан? pravoslavie.ru, 01.08.2012

¹⁴ congresomundial.es, 26 May 2012

¹⁵ Коран судар, хадисын ботиудад буй үг. Хөрвүүлбээс секс-боол, татвар эмс гэсэн үг.

¹⁶ Fatwa Permits Mujahideen to Kidnap, Imprison, and Have Sexual Intercourse with Infidel Women, The Middle East Media Research Institute report, November 30, 2011

¹⁷ Мөн тэнд

¹⁸ freewebs.com/shatornja/Srpske Novine 1.pdf

¹⁹ Сирия: что ждет христиан? pravoslavie.ru, 01.08.2012

²⁰ FoxNewsNetwork, 7 April, 2013

²¹ Прозелитизм (грекийн proselytus үгнээс гаралтай) – өөрийнхөө итгэл үнэмшлийг түгээхээр бусад шашин руу хандахыг эрмэлзэх үзэгдэл. Энэ үзэгдлийг лалын друз, алавит урсгалаас бусад бүх шашин зөвшөөрдөг.

²² John L.Esposito. The Islamic Threat: Myth or Reality, New York: Oxford University Press, 1992, p. 12